



**ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2019 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/89

Улаанбаатар хот

**Эрчим хүчний салбарын спортын олон
төрөлт наадамд оролцох тухай**

Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2, 13.1.3 дахь заалт, Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх заалт, Компанийн дүрмийн 8.11.11 дэх заалт, Захиргаа, ҮЭХ-ны хооронд байгуулсан 2017-2018 оны Хамтын гэрээний 3.20 дахь заалт, Эрчим хүчний яамны б/2228 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрчим хүчний салбарын Спортын олон төрөлт наадамд оролцох нэгдүгээр хавсралтад заасан нэр бүхий 27 ажилтныг 2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс 2019 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд ажлаас чөлөөлсүгэй.
2. Тэмцээний бэлтгэл ажлыг хангаж, тамирчдыг нэгдсэн удирдлагаар зохион байгуулж оролцуулахыг спорт хамтлагийн ахлагч, Цахилгаан ДХХА цехийн дарга /С.Батсайхан/-д даалгасугай.
3. Спорт наадмын төсөв болох 15578500 /Арван таван сая таван зуун далан найман мянга таван зуу/ төгрөгийг хоёрдугаар хавсралтаар баталж, зардлыг ажилчдын нийгмийн зардлаас тооцох, дээрх тамирчдад чөлөөтэй байх хугацааны үндсэн цалин, бусад нэмэгдлийг олгохыг Санхүү бүртгэл, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /Б.Даваадулам/-д даалгасугай.
4. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс /Б.Гоёцэцэг/-т үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



С.БЯМБААХҮҮ

Tushaal.2019

360000551